



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛ 2023



Улаанбаатар хот
2024



НИЙГМИЙН ДААТГАЛ

2023 онд Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 6385 байгууллагын нийт 209.3 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 131.8 (62.9%) мянга нь ААНБ-ын, 14.3 (6.8%) мянга нь төсвийн байгууллагын, 10.8 (5.2%) мянга нь сайн дурын даатгуулагчид, 52.5 (25.1%) мянга нь эрүүл мэндийн

даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛ-аар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нийт байгууллагын тоо	3 172	3 594	4 090	4 387	5 056	5 691	6 385
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	3 050	3 469	3 958	4 264	4 929	5 565	6 256
Төсөвт байгууллагын тоо	122	125	132	123	127	126	129
Нийт даатгуулагчдын тоо	195 327	141 035	186 443	130 156	149 174	180 207	209 359
ААНБ-ын даатгуулагчийн тоо	69 388	82 412	94 468	92 766	97 402	116 590	131 761
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	11 664	12 211	12 650	12 721	13 881	14 065	14 276
Сайн дурын даатгуулагчийн тоо	9 948	9 827	9 578	9 068	9 295	10 059	10 815
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	104 327	36 585	69 747	15 601	28 596	39 493	52 507

Тайлбар: Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс

2023 онд дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 598.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 56.0 (10.3%) тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛ-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт, сан тус бүрээр, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2022	2023	2022	2023	2022	2023
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	303 778	386 615	343 258.5	425 770.9	113.0	110.1
Тэтгэмжийн сангийн орлого	23 428	35 174.9	29 141.3	39 368.9	124.4	111.9
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	20 554.2	30 132.7	25 827.1	34 825.6	125.7	115.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	5 084	7 497.8	11 416.3	15 441.8	224.6	206.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	59 826.4	83 516.3	59 826.4	83 516.3	100.0	100.0
Нийт	412 670.6	542 936.7	469 469.6	598 923.5	113.8	110.3


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 71.1 хувийг тэтгэврийн даатгалын санд, 6.6 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 5.8 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 2.6 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 13.9 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 1. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого сан тус бүрээр, хувиар



ЗУРАГ 2. Нийгмийн даатгалын сангийн зардал, хувиар




ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛ-ын сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Нийгмийн даатгалын сангийн орлого	143 170.8	189 305.0	258 464.3	163 659.9	283 259.6	469 469.6	598 923.5
Нийгмийн даатгалын сангийн зардал	143 728.2	189 849.9	221 367.1	215 374.1	339 789.3	464 639.6	591 627.5
Үүнээс:							
Тэтгэврийн даатгал	90 197.5	121 098.6	150 059.8	138 157.0	238 963.9	339 390.2	418 338.3
Тэтгэмжийн даатгал	11 083.7	16 089.7	15 097.7	13 664.7	28 301.7	28 982.0	39 002.6
ҮОМШӨ-ний даатгал	10 764.0	14 882.2	15 332.4	8 336.8	13 002.0	25 813.5	34 788.9
Ажилгүйдлийн даатгал	3 660.4	4 149.2	4 417.1	13 552.8	13 132.8	10 627.5	15 997.0
Эрүүл мэндийн даатгал	28 022.6	33 630.2	36 460.1	41 662.8	46 388.9	59 826.4	83 500.7

Тайлбайр: Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 70.7 хувийг тэтгэврийн, 6.6 хувийг тэтгэмжийн, 5.9 хувийг ҮОМШӨ-ний, 2.7 хувийг ажилгүйдлийн, 14.1 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛ-ын сангийн орлого, зардал, сая төгрөг



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 20397 хүнд 174.6 тэрбум төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй тэтгэвэр авагч 3526 хүнд 19.8 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1017 хүнд 5.9 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1472 хүнд 19.4 тэрбум төгрөгийг, ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж авагч 283 хүнд 376 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 15294 хүнд 4.0 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 5642 хүнд 16.2 тэрбум төгрөгийг, 599 хүнд оршуулгын тэтгэмж 1.2 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 160 хүнд 1.6 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 213.5 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 174 хүнд 223.2 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувиллын зардал 25 хүнд 7.1 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 3545 хүнд 16.0 тэрбум төгрөг зарцуулжээ.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН сангаас олгосон тэтгэвэр, сая төгрөг

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Олгосон тэтгэврийн хэмжээ	90 197.5	121 098.6	150 059.8	138 156.9	238 963.9	339 390.2	340 390.2
Өндөр насны тэтгэвэр	57 386.0	67 580.0	77 481.3	93 089.8	102 246.9	137 990.8	138 990.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	8 280.8	9 553.1	11 792.0	12 820.1	13 125.7	17 695.4	18 695.4
Тэжээгчээ алдсаны	2 293.9	2 580.3	3 072.6	3 338.5	3 516.7	4 973.7	5 973.7
Цэргийн тэтгэвэр	6 730.1	7 937.7	9 069.5	10 055.5	10 876.8	13 852.4	14 852.4
Бусад зарлага	15 506.7	33 447.5	48 644.4	18 853.0	109 197.8	164 877.9	165 877.9

Нийгмийн даатгалын таван төрлийн сангаас 598.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардлыг санхүүжүүлж, давхардсан тоогоор 209.3 мянга гаруй иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2022 оны мөн үеэс 56.0 тэрбум төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛ-ын сангаас тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт		2017	2018	2019	2020	2021	2022	2023
Тэтгэвэр авагчдын тоо		18 779	20 252	20 811	22 179	23 311	25 213	26 788
Үүнээс:	Өндөр насны тэтгэвэр	13 633	14 567	15 365	16 557	17 633	19 051	20 397
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	2 962	3 051	3 185	3 302	3 294	3 411	3 526
	Тэжээгчээ алдсаны	796	817	793	809	859	932	1 017
	Цэргийн тэтгэвэр	1 074	1 129	1 178	1 228	1 278	1 385	1 472
	ҮОМШӨ-ний	314	344	290	283	247	434	376

Тайлбар: Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс

Нийт олгосон тэтгэврийн 67.3 хувийг өндөр насны, 7.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.3 хувийг тэжээгчээ алдсаны, 7.5 хувийг цэргийн, 15.3 хувийг бусад зарлагад тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛ-ын сангаас тэтгэвэр авагчдын тоо, 2023 он /хувиар/



Танилцуулга бичсэн:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Энх-Амгалан